

БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС БОЛОН БНТУ, МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ

*Б.Мандхай**

I. Бүгд Найрамдах Турк Улсын тухай

БНТУ-ын тухай товчхон

Газар нутгийн хэмжээ (Дэлхийд энэ үзүүлэлтээр 36-р байранд ордог): 779.452 кв км Бүгд найрамдах улс
Хүн амын тоо (Энэ үзүүлэлтээр дэлхийд 15-р байранд бичигддэг): 2003 онд хийсэн статистикийн тооцоогоор 70.712.000 = нэг кв км-т 91 хүн ноогдоно.
Нийслэл хот: Анкара
Албан ёсны хэл: Турк
Нэг хүнд ноогдох Үндэсний Нийт Орлого: 2003 оны байдлаар 2.800 ам.доллар
Мөнгөний нэгж: 1 шинэ туркийн лир = 100 курус Ханш: 1 ам.доллар = 1,37 лир (2005 оны 7 дугаар сарын 1-ны байдлаар) 1 евро = 1,72 лир (2005 оны 7 дугаар сарын 1-ны байдлаар)
Ажилгүйдлийн төвшин: 10,3% (2004 оны байдлаар)

Нэг. Газар зүйн байрлал:

Бүгд Найрамдах Турк Улс (БНТУ) нь Ази, Европыг холбосон газар зүйн өвөрмөц байрлалтай. Нийгэм, эдийн засаг соёлын хувьд Ази, Европын аль аль шинж төрхийг хадгалсан онцлогтой улс юм. БНТУ Хар далай, Газрын дундад болон Эгийн тэнгис, Дарденэл, Босфорын хоолойгоор хүрээлүүлсэн усан хилтэй, мөн хуурай газраар баруун хойд хэсгээрээ Болгар, Грек зүүн хойд хэсгээрээ Гүрж, Армен, Азербайжан, өмнөд хэсгээрээ Иран, зүүн өмнөд хэсгээрээ Ирак, Сиритэй хиллэдэг.

Газар нутаг: Бүгд найрамдах Турк улс 779.452 кв км нутаг дэвсгэртэй, энэ нь Англи, Францын газар нутгийг нийлүүлсэнтэй тэнцүү. Газар нутгийн 97% нь Ази тивд харьяалагддаг. Хуурай газрын хилийн урт 2753 км, усан хилийн урт 8333 км, нутгийн өмнөөс умард цэг хүртэл 1500, тариалан эрхэлж болох газар 28 сая га. Энэ нь Испани, Италийн тариалангийн талбайг нийлүүлсэнтэй тэнцэх газар юм.

БНТУ нь засаг захиргааны хувьд 81 муж, газар зүйн 7 бүсэд хуваагддаг. Үүнд:

1. Мармарагийн бүс
2. Хар тэнгисийн бүс
3. Газрын дундад тэнгисийн бүс

4. Зүүн Анатолийн бүс
5. Эгийн бүс
6. Төв Анатолийн бүс
7. Зүүн өмнөд Анатолийн бүс

Цаг агаар: Хур тундасын жилийн дундаж 650 мм боловч бүс бүрт харилцан адилгүй байдаг. Тухайлбал, төв зүүн өмнөд хэсэгт 230 мм байхад, зүүн хойд, уулархаг мужид 2500 мм-т хүрдэг. Цаг уурын хувьд 4 бүсэд хуваагддаг. Үүнд:

1. Газрын дундад болон Эгийн тэнгисийн бүс
2. Мармара болон Хар тэнгисийн бүс
3. Төв Анатолийн бүс
4. Зүүн болон зүүн өмнөд Анатолийн бүс

Баруун, өмнөд хэсгийн далайн эрэг орчимд өвөл нь чийглэг, зун нь зөөлөн дулаан байдаг ажээ.

Хүн ам: Бүгд найрамдах Турк Улс нь 2006 оны 7-р сарын статистик тоо баримтаар 70.413.055 хүн амтай. Хүн амын 25.5 хувийг 0-14 насны, 67.7 хувийг 15-64 насны, 6.8 хувийг 65-аас дээш насны хүмүүс эзэлдэг. Хүн амын 80 хувь нь турк, 20% нь курд болон , араб, грек, армян, гүрж үндэстэн бөгөөд тэдний 98 хувь нь лалын шашинтан. Хүн амын 90 хувийн үндэсний хэл нь турк хэл юм. Дэлхий дээр хүмүүсийн ярьж буй 4000 орчим хэлнээс нэг хүнд оногдож ярьж буй хувиараа турк хэл 7-д ордог ажээ. Энэ хэлээр 200 сая гаруй хүн ярьдаг.

Томоохон хотууд:

Анкара (нийслэл) – 3.6 сая

Истанбул - 9.5 сая

Измир - 3.2 сая

Коня - 1.9 сая

Бурса - 1.9 сая

Адана - 1.7 сая

Анатоля - 1.4 сая

Хоёр: Төрийн тогтолцоо:

Турк улс нь бүгд найрамдах улсын төрийн тогтолцоотой. Энэхүү Бүгд найрамдах улсыг үндэслэгч Атапюрк (Мустафа Кемаль) 1923 оны 10 дугаар сарын 20-нд байгуулж, үндсэн хуулийг батлуулжээ. Энэ өдрийг БНТУ жил бүрийн 10 дугаар сарын 23-нд тэмдэглэн өнгөрүүлдэг болов. Атапюрк нь Туркийн нийгэмд эрх зүйн гүн гүнзгий шинэчлэлтийг богино хугацаанд хэрэгжүүлсэн. Тухайлбал Европын сонгомол орнуудын жишгээр эрүүгийн болон иргэний хуулийг

боловсруулснаас гадна шашныг төрөөс тусгаарласан тухай, эмэгтэйчүүдийн нүүрний бүтээлгийг халах тухай, араб үсгийг латин үсгээр солих тухай зэрэг лалын шашин ноёрхсон орны нийгэмд эрс өөрчлөлт хийхэд чиглэсэн хууль тогтоомжуудыг баталж мөрдүүлжээ.

Ингэснээр Туркийн нийгэм богино хугацаанд өрнө дахины соёл иргэншилтэй холбогдож, нийгэм эдийн засгийн бүхий л салбарт гүнзгий өөрчлөлт хийх голдиролд буцалтгүй оржээ. Мөн тэрээр Туркийн нутаг дэвсгэрийн төв хэсэгт оршдог Анкара хотыг нийслэл хот болгон хуульчилсан нь улс орны эдийн засаг, соёлыг бүх нутагт хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангахад чухал арга хэмжээ болсон гэж үздэг. Одоо үйлчилж буй үндсэн хуулийг 1982 оны 11-р сард баталсан. Туркийн Үндэсний Их Хурал (ТҮИХ)–аас 7 жилийн хугацаагаар нэг хүнийг нэг л удаа сонгодог. А.Н.Сээр 2000 оны 4 дүгээр сард ерөнхийлөгчөөр сонгогдсон ба эдүгээ ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

Хууль тогтоох эрх мэдлийг Туркийн Үндэсний Их Хурал хадгална. Туркийн Үндэсний Их Хурал 5 жилээр сонгогдоно. Туркийн Үндэсний Их Хурал нь 550 гишүүнтэй бөгөөд сүүлчийн сонгууль 1999 оны 4-р сарын 18-нд болсон.

Гүйцэтгэн захирах дээд эрхийг ерөнхийлөгч, ерөнхий сайд эдэлнэ. Ерөнхийлөгч ерөнхий сайдыг томилно. Гэхдээ энэ томилолтыг Туркийн Үндэсний Их Хурал батламжилдаг. ЗАН, ҮХН, ЭОН эвсэл байгуулж, 1999 оны 6-р сард эвслийн засгийн газрыг эмхлэн байгуулав. Ерөнхий сайдаар ЗАН-ын дарга Б.Эжэвитийг томилсон.

Гурав. Эдийн засаг:

БНТУ-ын 1980 оны 1-р сараас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих үзэл баримтлалыг мөрдөж, үүнийгээ тууштай хэрэгжүүлж байна. Энэ үзэл баримтлалд тодорхойлсон зорилтуудын дотроос хамгийн гол зорилт нь экспортод чиглэсэн үйлдвэржүүлэлтийг хэрэгжүүлэх явдал байв. Энэ зорилтоор мөнгө, хөрөнгийн уян хатан бодлого, экспорт, импорт, хөрөнгө оруулалтыг аль болохоор хөхиүлэн дэмжихэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрч байгаа ажээ. 1980-аад оны сүүлчээс зарим нэг бэрхшээл, тухайлбал, хүнсний бүтээгдэхүүн хэт үйлдвэрлэлт, инфляцийн өсөлттэй тулгарч ирсэн. Эдгээр бэрхшээлийг арилгах, эдийн засгийн тотвортой байдлыг хангах зорилт бүхий цогцолбор арга хэмжээг тусгасан “эдийн засгийг тогтворжуулах программ”-ыг 1994 оны 4-р сарын 5-аас хэрэгжүүлж байна.

Аж үйлдвэр: Аж үйлдвэрийн салбарт нэхмэл сүлжмэлийн үйлдвэр зонхилох байр эзэлдэг аж. Мөн хүнс химийн бүтээгдэхүүн, пластик,

шил шаазан, хар төмөр, ган, машин, сэлбэг, цахилгаан, техник, электроникийн үйлдвэр нилээд сайн хөгжсөн.

Өнөөдөр БНТУ нь дэлхийд нэхмэл, сүлжмэлийн гол үйлдвэрлэгч, экспортлогч орны нэг болж, энэ үзүүлэлтээрээ дэлхийд 6 дугаарт орж байна. Турк дэлхийн хувцасны зах зээлийн 3.3 хувийг эзэлж, 7 млрд ам.долларын хувцас экспортолж, 500 сая ам.долларын хувцас импортолж байна. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсадын 40 хувь нь энэ салбарт ажилладаг.

Хүнсний үйлдвэр аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний 20 хувийг үйлдвэрлэдэг. Энэ салбарын 25 мянган компанид 250 мянган хүн ажиллаж байна. Турк жилд 554 сая ам.долларын тамхи, 52 сая ам.долларын гоймон экспортолдог.

Арьс шир боловсруулах үйлдвэр нь нэхмэл сүлжмэлийн үйлдвэрийн дараа гадаадын валютын орлого оруулдаг хоёр дахь том салбар юм. Жилд 1 млрд ам.долларын экспорт хийж, 1.5 млрд ам.долларын бүтээгдэхүүнийг гадаадын жуулчдад шууд худалддаг ажээ.

Уул уурхайн салбарт- газрын тос нүүрсийг оролцуулахгүйгээр 4400 орчим ашигт малтмалын орд газар БНТУ-д байдаг аж. Алт, мөнгө, зэс, хром, бор, цайр, гянт, болд, чулуун болон хүрэн нүүрс, төмрийн хүдэр, гантиг олборлодог. Нүүрс төмрийн хүдрийг гол төлөв төрийн өмчийн үйлдвэрүүд олборлодог байхад барилгын материалын эрдсийг ихэвчлэн хувийн хэвшлийн үйлдвэрүүд олборлодог ажээ. Уул уурхайн салбар үндэсний нийт бүтээгдэхүүний 1.5 хувийг гаргаж байна.

Туркт дэлхийн борын нөөцний 65% байдаг. Жилд 2.5 сая тонн антрацит нүүрс, 60 сая тонн хүрэн нүүрс үйлдвэрлэж байна. Хүрэн нүүрсний нөөц 7.75 тэрбум тонн бөгөөд энэ үзүүлэлтээрээ дэлхийд 7 дугаарт ордог.

Эрчим хүч: БНТУ нь эрчим хүч импортлогч улс. Хэрэгцээт эрчим хүчний тал хувийг импортоор авдаг. Эрчим хүчний гол түүхий эд нь чулуун болон хүрэн нүүрс, газрын тос, байгалийн хий, ус, мод, модлог ургамал, амьтны гаралтай эрдэс, нарны эрчим хүч зэрэг болно. БНТУ-д дэлхийн нүүрсний нөөцийн 0.6%, усны нөөцийн 1% байдаг. Харин газрын тос, байгалийн хийн хувьд маш хязгаарлагдмал нөөцтэй.

Эрчим хүчний хүчин чадал 2004 онд 23000 мегаватт-д хүрч, 121.2 тэрбум киловатт цагийн эрчим хүч үйлдвэрлэжээ. 1998 онд нийт эрчим хүчний 64.9 хувийг дулааны цахилгаан станц, 35.1 хувийг усан цахилгаан станц гаргажээ.

Барилга: Энэ салбар нь хурдацтай, эрчимтэй хөгжиж буй салбарын нэг юм. Туркийн хүн ам хурдан өсч байгаатай уялдан орон сууц болон бусад барилга байгууламжийг олноор барих бодитой

шаардлага гарсан тул барилгын аж үйлдвэрийг олон тоогоор богино хугацаанд барьж ашиглалтанд оруулж байна. Туркийн барилгын компани нь зөвхөн дотооддоо төдийгүй гадаадын олон оронд барилгын зураг төсөл өөрсдөө хийж, захиалгаар төрөл бүрийн барилга өөрсдөө барьж байна. Одоо гадаад орнуудад туркийн барилгачид 30 тэрбум ам.долларын барилга гэрээгээр барьж байгаа бөгөөд энэ нь дэлхийн хэмжээнд гадаадын компаний гэрээгээр барьж буй барилгын 10 хувьтай тэнцэж байгаа болно.

Зам тээвэр, холбоо: Зам тээвэр, холбооны салбар хамтдаа дотоодын нийт бүтээгдэхүүний 15 хувийг эзэлдэг. Дотоодын тээврийн 89.3 хувийг авто тээврээр, 5.6 хувийг төмөр замын тээвэр, 1.8 хувийг хийн хоолойн тээвэр гүйцэтгэдэг. Нэг үгээр хэлбэл, дотоодын тээврийн 95 хувийг газраар гүйцэтгэж байна. 2004 оны байдлаар БНТУ хот тосгодыг холбосон улсын хэмжээнд 350.000 км урт авто замын сүлжээтэй байна. Үүнээс

- өндөр хурдны зам - 62000 км
- сайжруулсан хатуу хучилттай зам – 154035 км
- чулуун хучилттай – 72529 км
- хучилтгүй зам – 49889 км
- төмөр замын урт – 10466 км

Далайн тээвэр–1997 онд 10 сая тонн ачаа тээвэрлэсэн. Туркийн олон улсын ачаа тээврийн 33 хувийг усан замын тээвэр гүйцэтгэж байна.

II. Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын сүүлийн үеийн харилцаа

Монгол Улс, Турк Улс нь газар зүйн хувьд алс зайдуу оршдог боловч хэдэн мянган жилийн тэртээгээс түүх, соёлын хэлхээ холбоотой байсан билээ.

Түрэгийн хаант улс нь VI-VII зууны үед Төв Азид тогтнож байсан феодалын түрүү үеийн улс билээ. Түрэг аймгууд 552 онд Жужаныг бут цохиж Түмэнээр толгойлуулсан Түрэгийн хаант улсыг байгуулсан байна. Түрэгийн хаант улс 555 онд төв Азийг бүхэлд нь эзлэн худалдааны их замыг ноёрхож, Хятан умард Манж, Енисейн Киргизийг байлдан эзэлж, 570-аад онд Умард Хятадыг эрхэндээ мөн оруулж татвар авч байсан аж. Түрэгийн хаант улсын нийслэл нь Орхоны эхэнд байсан ба 580-аад оны дайны үр дүнд Түрэгийн хаант улсын нутаг дэвсгэр өргөжиж Солонгосын булангаас Амударьяа, Цагаан хэрмээс Байгаль нуур хүрч байв. Түрэгийн хаант улс нь мал аж ахуй зонхилон

эрхэлж, ан гөрөө, газар тариалан, уран дархан, гар урлалыг хийж байсан зэрэг нь манай хоёр орны ард түмэн олон зуун жилийн өмнө нэг нутаг, дэвсгэрт оршин амьдарч байсан нь тодорхой бөгөөд энэ талаарх мэдээллийг бид Монгол Улсын нутаг дахь түрэгийн үеийн дурсгалын бичээс, зураг сэлтээс тодорхой мэдэж болдог билээ.

Түрэгийн ард түмний удам угсаа нь хэд хэдэн тусгаар улс, өөртөө засах орон, мужид оршин амьдардаг билээ. Тэдний томоохон нэг нь Турк үндэстэн юм.

Турк, Монгол хоёр орны хооронд дипломат харилцаа 1969 оны 6-р сарын 24-нд тогтсон боловч дэлхийн улс төр, үзэл суртлын ялгаанаас болж, манай хоёр орны харилцаа 1990-ээд оныг хүртэл амжилттай хөгжиж чадаагүй байсан байна. Монгол Улсад ардчилал, өөрчлөлт шинэчлэлийн үйл явц өрнөж, нээлттэй гадаад бодлого явуулах болсны үр дүнд хоёр орны найрсаг харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх боломж нээгдэн, Монгол Улстай харилцах Туркийн сонирхол өссөн зэргээс тус хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд идэвхжин хөгжив.

БНТУ, манай улсын дипломат харилцаа 1990-ээд оноос идэвхитэй хөгжиж харилцаа, хамтын ажиллагаа болон тус улсын манайд үзүүлэх хөгжлийн тусламж, ирэх очих хүмүүсийн тоо олширсоор ирсэн билээ.

Туркийн засгийн газрын урилгаар манай ГХ-ны сайд 1992 оны 5 дугаар сард Турк улсад анх удаа айлчлав. Тус айлчлалын үеэр “Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ” байгуулж, “Худалдаа эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр”, “Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Дипломат болон албан паспорттай иргэд харилцан визгүй зорчих тухай хэлэлцээр”, тэрчлэн цаашид байгуулбал зохих хэлэлцээр, протоколуудын талаарх тохиролцоонд тус тус гарын үсэг зурж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зарим хууль зүйн гол үндэс суурийг тавьсанаараа чухал ач холбогдолтой юм. Ийнхүү манай ГХ-ны сайд Туркт анх удаа айлчилсан нь хоёр орны харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал алхам болов.

Турк улс 1996 онд Улаанбаатар хотноо ЭСЯ-аа нээж, Монгол Улс 1997 онд Анкара хотод ЭСЯ-аа нээв.

Үүнээс хойш хоёр тал олон удаа элчин сайд нараа харилцан солилцож итгэмжлэх жуух бичгээ барьсан үеэс эхлэн Туркийн тал Түрэгийн үеийн хөшөө дурсгалыг сэргээн засварлан, санхүүжүүлж, түүнийг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх сонирхолтой тухай Засгийн газар хоорондын протокол байгуулагдан хэрэгжиж эхэлсэн төдийгүй манай улсад үзүүлж буй хөгжлийн тусламжийн хэмжээ өссөн юм.

Тухайлбал: боловсролын шугамаар манай улсаас Турк улсад суралцах бакалавр, магистрийн тоог жил бүр нэмэгдүүлж сургах, Монгол, Туркийн хамтарсан Лицей сургуулийг Дархан, Эрдэнэт, Баян-Өлгий аймагт байгуулсан байна. Мөн Туркийн ТИКА олон улсын байгууллагын тусламжаар МУИС-д 2001 оноос эхлэн Түрэг судлалын тэнхим байгуулж түрэг судлаач мэргэжилтэн бэлдэж байна. Монгол дахь Түрэгийн үеийн хөшөө дурсгалыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Өвөрхангай аймгийн Хархорин сумаас Хөшөө Цайдам, Түрэгийн үеийн хөшөө, дурсгал хүртэлх 40 км авто замын техник, эдийн засгийн судалгаа, зураг төслийг Туркийн талтай хамтран боловсруулж улмаар “Монголын нутаг дээрх Түрэгийн үеийн хөшөө, дурсгалыг сэргээн засварлах, хамгаалах” төслийн хүрээнд уг замыг Турк улсын буцалтгүй тусламжаар хамтран барьж байгаа билээ. Мөн манай зэвсэгт хүчний албан хаагчдыг Турк улсад энхийг сахиулах үйл ажиллагаанд хамруулах, боловсруулахад тус дөхөм болох үүднээс цэргийн албан хаагчийг сургаж байгаа гэх мэтчилэн хөгжлийн тусламж үзүүлсээр байгаа билээ.

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд 2006 оны 11 сарын 02-06-ны хооронд БНТУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр хэд хэдэн чухал асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэв.

Монгол, Туркийн хамтарсан хэвлэлийн бага хурал дээр БНТУ-ын ерөнхий сайд Р.Т.Ердаон нь Турк, Монголын худалдааны эргэлт эдүгээ 5 сая ам.доллар байгаа нь удахгүй 50 сая ам.доллар болно гэж мэдэгдэв. Мөн хоёр орны худалдаа эдийн засгийн харилцааг дэмжихэд чиглэгдсэн хэд хэдэн асуудлууд дэвшүүлэв. Үүнд:

- Монгол дахь чөлөөт бүсийг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихээс гадна барилга, хот байгуулалт, эрчим хүч, гамшигтай тэмцэх, өрсөлдөөнийг хянан зохицуулах, мэргэжлийн хяналт зэрэг шинэ шинэ салбаруудад хамтын ажиллагааг эхлүүлэх асуудлыг дэвшүүлэв.

- Монгол Улсад арьс ширний аж үйлдвэрийн цогцолбор байгуулах, хөдөө аж ахуйн салбарт байгуулах загвар фермийн аж ахуй барих зэрэг хоёр талаас багагүй хүчин чармайлт хамтын ажиллагааны асуудлууд ч яригдав.

- Турк улс цэргийн техникийн шинэчлэл сургалтад зориулж 300 мянган ам.долларын буцалтгүй тусламж олгов. Монголын Засгийн газраас хэрэгжүүлж буй 40 мянган айлын орон сууцны хөтөлбөрт Туркийн шинэ техник, технологийг нэвтрүүлэх хөрөнгө оруулалт хийх таатай боломж байгааг туркийн бизнесменүүдэд сонордуулав.

- Мөн Улаанбаатараас Истанбул, Истанбулаас Улаанбаатарын хооронд шууд нислэг 1996-1997 онд багахан хугацаанд хэрэгжээд

зогссон явцыг дахин сэргээх талаар хэлэлцэн шийджээ. Айлчлалын үеэр Ерөнхий сайд М.Энхболд Анкара хотод Монголын их эзэн Чингис хааны хөшөө боссоньг дурдаад “...удахгүй Улаанбаатар хотноо Анкарагийн нэрэмжит гудамж бий болно” гэж хэлсэн нь удахгүй биелэлээ олох биз ээ.

- Ерөнхий сайд М.Энхболдыг Ойрхи Дундын Техникийн Их Сургуульд зочилж үйл ажиллагаатай нь танилцах үеэр ШУТИС, БНТУ-ын Ойрхи Дундын Техникийн Их Сургууль хооронд хамтран ажиллах тухай санамж бичигт ШУТИС-ын ректор Б.Дамдинсүрэн, БНТУ-ын Ойрхи Дундын Техникийн Их Сургуулийн ректор Урал Акбулут нар харилцан гарын үсэг зурлаа.

Уг сургууль нь Туркт төдийгүй бүс нутагтаа томоохонд тооцогдох технологийн паркттай бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч шинжлэх ухаан төрийн бодлогыг уялдуулан зохицуулах үйл явдлыг амжилттай туршин хэрэгжүүлж байгаа юм. Ийм техно паркийг Монголд ШУТИС-ын дэргэд байгуулж өгөхөөр энэхүү санамж бичгээр тохиролцож байгаа юм.

Цаашид хоёр улсын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд боловсрол, зам тээвэр, эдийн засаг, худалдаа болон Монгол дахь чөлөөт бүсийг хөгжүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тодорхой зорилтууд тусгагдсанаас гадна барилга, хот байгуулалт, эрчим хүч, гамшигтай тэмцэх, өрсөлдөөнийг хянан зохицуулах, мэргэжлийн хяналт зэрэг шинэ шинэ салбаруудад хамтын ажиллагааг хэрэгжүүлж эхлүүлэх гэрээ хэлэлцээр байгуулсан нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэн өргөжүүлэх нь дамжиггүй биз ээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монголын нэвтэрхий толь II боть, УБ, 2000
2. Avrasya bulteni /Tika агентлагаас эрхлэн гаргадаг/ сэтгүүл
3. <https://www.CIA.Gov>.
4. “Монцамэ мэдээ” сонин
5. “Гадаад харилцаа” сэтгүүл 2001 он.
6. “Гадаад харилцаа” сэтгүүл 2004 он.
7. “Монгол улс Исламын шашинт орнуудын харилцаа”
М.Хурметхан
8. www.Tika.gov.tr
9. “Ардын эрх” сонин 1998.3.18. №65 / 349 /
10. “Өнөөдөр сонин” 2002.06.08